

## **ХЭЭЛ ХАХУУЛЬ, АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭЖ БАЙГАА ШҮҮХИЙН ПРАКТИКИЙН ТУХАЙ**

2004 оны 06 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

Хээл хахууль, албан тушаалын гэмт хэргийн гаралт жил бүр өсөх хандлагатай болж энэ төрлийн гэмт хэргийн талаар хэвлэл мэдээллээр гарч байгаа мэдээлэл, иргэдийн гомдолтой холбогдуулан Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхим, Шүүхийн Судалгааны төвөөс 2003, 2004 оны эхний улирлыг хамруулан энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэж байгаа шүүхийн практик, зарим анхаарах асуудлуудын талаар судалгаа хийв.

Судалгаанаас үзэхэд 2003, 2004 оны 1 дүгээр улирлын байдлаар Монгол Улсын шүүхээр хээл хахууль, албан тушаалын гэмт хэрэг тухайлбал, Эрүүгийн хуулийн 150, 175.1, 271, 272, 281, 294, 295, 263, 264, 265, 268, 253, 269, 270 зэрэг зүйл заалтаар 39 хэрэгт 58 хүн ял шийтгүүлсэн байна.

Энэ төрлийн хэрэгт ял шийтгүүлсэн шүүгдэгч нарын эрхэлсэн ажил, албан тушаалын байдлыг авч үзвэл: гаалийн хорооны дарга, гаалийн байцаагч 7, цагдаагийн ажилтан 5, татварын байцаагч 8, бусад байгууллагад ажиллагсад 38 байна.

Дээрхи төрлийн гэмт хэргийн объектив талыг авч үзвэл гаалийн хорооны дарга, гаалийн байцаагч, ажилтнууд нь албан тушаалынхаа байдлыг урвуулан эсвэл албан үүрэгтээ хайнга хандсаны улмаас хил гаалиар нэвтрүүлэхийг хориглосон буюу хязгаарласан барааг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, гаалийн татвар авахгүй байх, цагдаагийн ажилтнууд нь иргэний үнэмлэх, гадаад паспортын үнэ, хохирол, төлбөрийн мөнгийг хувьдаа ашиглах, албаны бүрэн эрхээ хэтрүүлэн хүний бие махбодид гэмтэл учруулах, зарим сэжигтэн, яллагдагчид холбогдох эрүүгийн хэргийг нуун дарагдуулах, хэргийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлэх, татварын байцаагч, төсөвт болон төрийн бус байгууллагын нягтлан бодогч, нярав нар нь албан тушаалын байдлаа урвуулан буюу эрх мэдлээ хэтрүүлж баримт бичгийг зориуд хуурамчаар үйлдэн төсвийн хөрөнгийг дур мэдэн хувьдаа завших, бусдад шилжүүлэх, эдгээр үйлдэлдээ бусдаас хээл хахууль авах зэргээр үйлдэгджээ.

Шүүхээс хээл хахууль, албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдэд оногдуулсан ялын байдлыг авч үзвэл /58 хүний/ 22.4 хувь буюу 13 хүнд торгуулийн ял, 43.1 хувь буюу 25 хүнд хорих ял, 5 хүнд баривчлах ял оногдуулж хянан шийдвэрлэжээ. Хорих ял оногдуулсан 25 хүний 48 хувь буюу 12 хүний хорих ялыг биечлэн эдлүүлж, 36 хувь буюу 9 хүний хорих ялыг тэнсэж, 4 хүний хорих ялыг тодорхой хугацаагаар хойшлуулж, 2 хүний ялыг 2000 оны Өршөөлийн хуульд хамруулж, 12 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

Албан тушаал, хээл хахуулийн хэрэгт шийтгэгдсэн байдлыг шүүхийн харьяаллаар нь авч үзвэл Дорноговь аймгийн шүүх 4 хэрэгт 5 хүн, Хөвсгөл

аймгийн шүүх 2 хэрэгт 3 хүн, Хэнтий аймгийн шүүх 3 хэрэгт 5 хүн, Дархан-Уул аймгийн шүүх 4 хэрэгт 5 хүн, Увс аймгийн шүүх 1 хэрэгт 2 хүн, Завхан аймгийн шүүх 2 хэрэгт 2 хүн, Өвөрхангай аймгийн шүүх 2 хэрэгт 5 хүн, Дорнод аймгийн шүүх 1 хэрэгт 3 хүн, Орхон аймгийн шүүх 1 хэрэгт 2 хүн, Говьсүмбэр аймгийн шүүх 4 хэрэгт 8 хүн, Баян-Өлгий аймгийн шүүх 1 хэрэгт 1 хүн, Төв аймгийн шүүх 1 хэрэгт 1 хүн, Дундговь аймгийн шүүх 3 хэрэгт 3 хүн, Өмнөговь аймгийн шүүх 5 хэрэгт 5 хүн, Нийслэлийн дүүргийн шүүхүүд 5 хэрэгт 9 хүн тус тус ял шийтгэсэн байна.

Сүүлийн жилүүдийн шүүхийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж үзэхэд хээл хахууль, албан тушаалын гэмт хэргийн тоо цөөн байгаа ч хохирлын хувьд жилээс жилд өсөж байгаа нь энэ гэмт хэргийн арга, үйлдэл нарийсан нуугдмал хэлбэрт орж байгааг харуулж байна.

Судалгаанаас харахад Дорноговь, Дархан-Уул аймгийн шүүхээр ял шийтгүүлэгсдийн ихэнхи нь гаалийн хорооны дарга, гаалийн байцаагч нар, Хөвсгөл, Дундговь аймагт ял шийтгүүлэгсдийн дийлэнхи нь цагдаагийн ажилтнууд, Өмнөговь аймгийн шүүхээр ял шийтгүүлэгчдийн олонхи нь шатахуун түгээх станцид түгээгч, Засаг даргын Тамгын газрын ажилтан, Говьсүмбэр аймгаар ял шийтгүүлэгсэд татварын байцаагч нар, Хан-Уул дүүргийн шүүхээр ял шийтгүүлэгсэд Иргэний агаарын тээвэр, Хилийн цэргийн 0218 дугаар ангид ажиллагсад байна.

Харин хээл хахууль өгсөн, зуучилсан 2 хэрэгт 3 хүн ял шийтгүүлжээ.

Шүүхээс хээл хахууль, албан тушаалын гэмт хэрэгт эрүүгийн ял шийтгэл оногдуулахдаа уг гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хор уршгийн шинж чанар, хохирлын хэмжээ, хариуцлагыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзан үзэж байх эрүүгийн эрх зүйн үндсэн зарчмыг анхаарч үзэхгүйгээр дэндүү хөнгөн ял оногдуулах, хөнгөн гэмт хэрэг гэсэн үндэслэлээр эрүүгийн хариуцлагаас чөлөөлж байгаа зэрэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрүүгийн хариуцлагын зорилгод нийцэхгүй байгааг нийт шүүхүүд анхаарвал зохино.

Тухайлбал: 1. Дорноговь аймгийн Замын Үүд дэх Гаалийн газарт улсын байцаагч ажилтай Намсрайпүрэв овогтой Сугаржалба гэгч нь албан үүрэгтээ хайнга хандаж их хэмжээний эд зүйлийг хууль бусаар Монгол Улсын хилээр нэвтрүүлж улсад 47.114.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт Дорноговь аймгийн сум дундын 2 дугаар шүүх 2003 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 23 дугаар шийтгэх тогтоолоор 1987 оны Эрүүгийн хуулийн 194 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар 170000 төгрөгөөр торгох ял шийтгэсэн байна. Гэтэл Н.Сугаржалба гэгч шүүх хуралдааны маргааш буюу 2003 оны 2 дугаар сарын 21-ний өдөр дахин албан үүрэгтээ хайнга хандаж 9.450.000 төгрөгийн эд зүйл улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн гэмт хэрэг давтан үйлдсэн байхад мөн аймгийн сум дундын шүүх 2003 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 113 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар 3 жилийн хугацаагаар хорих ял оногдуулж шийтгэн, уг ялыг 2 жил 6 сарын хугацаагаар тэнсэж хянан харгалзжээ.

Н.Сугаржалба гэгч нь 2 дахь удаагаа нэг төрлийн гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдэж байхад шүүх ял шийтгэл оногдуулахдаа гаалийн байцаагчийн албан тушаал эрхлэх эрхийг хасах үндэслэл байгааг ч анхаараагүй байна.

2. Хөвсгөл аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны даргын ажил эрхэлж байсан О.Баасан гэгч нь албан тушаалаа хэтрүүлэн ашиглаж иргэд байгууллагад үлэмж хэмжээний хохирол учруулсан үйлдлийг шүүх Эрүүгийн хуулийн 264 дүгээр зүйлийн 264.1-д зааснаар эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэлтэй байсан ч уг гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэрэг, учирсан хохирлоо төлсөн, хохирогчтой эвлэрсэн гэсэн дүгнэлт хийж, түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн байна.

О.Баасан гэгч нь уг албан тушаалыг хашиж байхдаа 1997 онд албан тушаалаа ашиглан улсад их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдэж мөн аймгийн сум дундын шүүхийн 1997 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 18 дугаар таслан шийдвэрлэх тогтоолоор 1 жилийн хорих ял шийтгүүлж, уг ял нь мөн хугацаагаар тэнсэж хянан харгалзагдаж байжээ.

О.Баасан нь тэнсэж хянан харгалзах хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдээгүй, ялгүй болсон хэдий ч О.Баасанг засарч хүмүүжсэн гэж үзэх үндэслэлгүй байхад түүний сүүлчийн буюу 2003 оны үйлдлийг хэрэгсэхгүй болгон эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх нь зохимжтой эсэхэд шүүх дүгнэлт хийх байжээ.

Дээрхи судалгааг үндэслэн нийт шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч нарт Зөвлөмжлөх нь:

1.Албан тушаал, хээл хахуулийн гэмт хэргээс улс, байгууллага, иргэдэд учруулсан хохирол, төлбөрийн биелэлт харьцангуй бага байгаа тул шүүхийн шатанд хөрөнгө битүүмжлэх, хохирол, төлбөрийг барагдуулах асуудалд анхаарч ажиллах.

2.Хээл хахууль, албан тушаалын гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд шүүхийн ялын бодлого үр нөлөөтэй болохыг анхаарч, энэ төрлийн гэмт хэрэгт шийтгүүлэгсдэд оногдуулах ялыг ялгамжтай, зөв тэнцвэртэй оногдуулах, хуулийн үндэслэлгүйгээр тэнсэх, ял хойшлуулах, ялангуяа урьд нь албан тушаалын гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдэд хуульд заасан ялын аль хөнгөн төрлийг сонгон хэрэглэх, хэргийг хэрэгсэхгүй болгон, цагаатгаж байгаад дүгнэлт хийж эдгээр зөрчил дутагдлыг давтан гаргахгүй байх.

**ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ТАНХИМ**

**ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ**